

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗАР

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2026 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 25

№01

Улаанбаатар хот

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох хууль, тогтоомжийг мөрдлөг болгон өргөдөл, гомдлыг шуурхай хүлээн авч, иргэнд үндэслэлтэй хариу өгөх, бүрэн шийдвэрлэхэд анхаарч ажиллаж байна.


Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт 2026 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар иргэдээс ирүүлсэн нийт 171 өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэсэн. Үүнд: Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс 3, 1800-1200 дугаарын оператораас 4, 11-11 төвөөс 53, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага дээр өөрийн биеэр ирж бичгээр болон амаар өгсөн 111 өргөдөл, гомдлыг “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем буюу “UB-ERP” системд бүртгэсэн.

Ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилбал:

Хүсэлт 105 буюу 61.5%, гомдол 65 буюу 38%, санал 1 буюу 0.5%, тус тус ирсэн.

Өргөдөл, гомдлын төрлийг 2026 оны 1 дүгээр улирлын тайланг 2025 оны мөн үетэй харьцуулж үзүүлбэл.

Өргөдөл, гомдлын төрлийн тайлан



■ 2025 ■ 2026

Графикаас харвал иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоо 2025-2026 онд өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэсэн 147 буюу 85.96%, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байхгүй, шийдвэрлэх шатандаа хугацаандаа байгаа 24 буюу 14.04% -тай байна.

Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 85.96 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нийт 147 өргөдөл, гомдлын тоог шийдвэрлэлтийн хугацаагаар нь авч үзвэл:


5 хоногт 67 буюу 45.58%,

10 хоногт 31 буюу 21.09%,

15 хоногт 15 буюу 10.20%,

30 хоногт 33 буюу 22.45%,

Хугацаа сунгаж 1 буюу 0.68%-ийг тус тус эзэлж байна.



Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 18 цаг 40 минут нийт 147 өргөдөл, гомдол байна.

Өмнөх онтой харьцуулахад 2026 онд иргэдээс ирж буй өргөдөл, гомдол өссөн.

Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.

Ирсэн өргөдөл, гомдлыг хандалтаар үзвэл:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь
1	Газрын гэрчилгээ, лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт хүсэх тухай	53	34.19%
2	Газрын гэрээ, гурван талт гэрээний тухай	27	17.42%
3	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн тухай	14	9.03%
4	Дахин төлөвлөлтийн талаар лавлагаа хүсэх тухай	12	7.74%
5	Барилга, байгууламж барих, өргөтгөх тухай	8	5.16%
6	Дахин төлөвлөлтөнд хамрагдах хүсэлтийн тухай	8	5.16%
7	Барилгын лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт хүсэх тухай	6	3.87%
8	Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тухай	5	3.23%
9	Иргэний ахуйн зориулалтаар (0.07 га) газар өмчлөх хүсэлтийн тухай	5	3.23%
10	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	5	3.23%
11	Барилга, байгууламжийн зориулалтыг хянах тухай	2	1.29%
12	Барилга, байгууламж буулгах тухай	2	1.29%
13	Барилгын салбарын үйл ажиллагааны тухай	2	1.29%
14	Цалинтай чөлөө хүсэх тухай	1	0.65%
15	Барилга, байгууламжийн маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай	1	0.65%
16	Барилга, байгууламжийг зөвшөөрөлтэй эсэхийг шалгуулах тухай	1	0.65%
17	Барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдлын тухай	1	0.65%
18	Газар чөлөөлөх тухай	1	0.65%
19	Барилга, байгууламжийн ажлыг зогсоох тухай	1	0.65%
Нийт өргөдөл, гомдлын дүн		155	100.00%

Тайлант хугацаанд шийдвэрлэсэн нийт өргөдөл, гомдлын тоог хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл:

Програм хангамж, мессеж болон албан бичгээр 54,

Програм хангамж, иргэнтэй биеэр уулзаж хариу өгсөн 25,


Мессеж болон утсаар 68 хариуг өгч тус тус шийдвэрлэсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл нийт 147 иргэнд хариу өгч шийдвэрлэсэн.

Үүнд:

-Иргэний талд шийдвэрлэсэн хариу өгсөн- 97 өргөдөл

-Боломжгүй тухай хариу өгсөн- 50 өргөдөл



2026 оны нэгдүгээр улирлын байдлаар төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаанаас шалтгаалж орон сууц ашиглалтад орох гэрээнд тусгагдсан хугацаа удааширснаар өргөдөл, гомдлын тоо харьцангуй өссөн үзүүлэлттэй байна.

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар газрын гэрчилгээ, лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт авах, газрын гэрээ, гурван талт гэрээний тухай, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд гурван талт гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй тухай өргөдөл илүү их хувийг эзэлж байна

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол нь:

-Газрын гэрчилгээ, лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт авах, тухай өргөдөл

-Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд гурван талт гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй тухай өргөдөл

-Гурван талт гэрээг цуцалж газар, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээгээ авах тухай өргөдөл

-Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны хүрээнд гурван талт гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй тухай өргөдөл

-Төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсны улмаас 2 талт захиалгын гэрээтэй иргэд орон сууц ашиглалтад орох хугацаа хойшилсон тухай өргөдөл

Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.